**ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.БУЛГАНТАМИРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилго 1. “Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.”** | | | | | | | |
| **Зорилт 1.1. Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 1.1 | Мэс заслын тусламж, үйлчилгээний эмнэлгийн өндөр өртөгтэй хэрэгслийн үнийн судалгааг хийнэ. | Үнийн судалгаа хийгдсэн байна. | Судалгаа бүрэн хийгдээгүй | ЭМБ-аас тоон мэдээлэл цуглуулах тоо мэдээг цэвэрлэх, нэгтгэх | 2023 онд эрүүл мэндийн даатгалын санд ирүүлсэн мэс заслын тусламжийн нийт нэхэмжлэлийн 98%-ийн дата мэдээлэл буюу 12 эрүүл мэндийн байгууллагын 270,000 гаруй дата (154,000 өвчний) цуглуулсан. Уг дата мэдээллийг ЭМБ бүрээс цуглуулахад 30 удаагийн зөвлөгөө мэдээллийг хүргэсэн. Мөн цуглуулсан дата мэдээллийг дүн шинжилгээ хийхэд зориулж эмхлэн, цэвэрлэж, нэгтгэсэн. Уг дата мэдээллийг цуглуулахад үйл явцад газрын мэргэжилтэн бүрийг excel програмд хэрхэн хурдан хугацаанд дата мэдээлэлтэй ажиллах талаар анхаарах зүйлсийг тухай бүр тайлбарлан чиглүүлж ажилласан. Энэхүү тооцооллоор ЭМДҮЗ-ийн мэс заслын тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээ 50 орчим хувь нь буурахаар тооцоолол гарсан тул шинэчилсэн тогтоолд тусгаагүй бөгөөд цаашид ЭМСайдын 2019 оны 611 дүгээр тушаалыг цахим системээр эрүүл мэндийн байгууллагаас мэдээллийг бодит цагийн горимоор хүлээн авах ажлыг төлөвлөн гүйцэтгэж байна. | 2024.01.01<br>2024.05.24 | 100% |

| Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана. | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.1 | ЭМДҮЗ-ийн "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоолын амбулаторийн багц, өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээний хэрэгжилтийг үнэлж, цаашид авах арга хэмжээг тодорхойлон, хэрэгжүүлэн ажиллана. | Судалгаа, үнэлгээ гаргасан байна. | - | Дата мэдээллийг авах | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 01, 08 дугаар тогтоолын амбулаторийн багц, өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний гүйцэтгэлд нарийвчилсан судалгаа холбогдох тооцооллыг гүйцэтгэсэн. ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хуралдаанаар түс 2 тусламж, үйлчилгээг нэгтгэн амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багцийг үүсгэсэн. Мөн ЭМДҮЗ-ийн "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 14 дүгээр тогтоолыг боловсруулан ЭМЯ болон Сангийн яамнаас санал авч ЭМДҮЗ-өөр хэлэлцүүлэн 14 дүгээр тогтоолыг батлуулсан. ЭМДҮЗ-ийн "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 06 дугаар тогтоолыг шинэчлэн батлуулахад амбулаторийг цогц тусламж, үйлчилгээний өртөг, даатгуулагчийн оношилгоо, шинжилгээний хэрэглээний судалгааг гүйцэтгэн ажиллаж байна. | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| 1.2.2 | ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоож, ЭМДҮЗ-ийн тогтоолоор | Тогтоолын төсөл боловсруулахад шаардлагатай тоо мэдээллийг боловсруулсан байна. | Дата мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. | Тогтоолын төсөл боловсруулахад шаардлагатай тоо мэдээллийг боловсруулах | ЭМДҮЗ-ийн "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоолын төслийн боловсруулахад шаардлагатай анхан шатны 4 төрөл, нэг иргэнээр санхүүжих тусламж, үйлчилгээний 2023 оны дата мэдээллийг боловсруулан, үр дүнг үнэлсэн. Мөн тогтоолын өөрчлөлтийн анхны хувилбар танилцуулах илтгэлийг бэлтгэхэд оролцож ажилласан. ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтоолыг шинэчлэх батлуулахаар тогтоолын | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулж, хэрэгжүүлнэ. | | | | төслийг дахин боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр байршуулж олон нийтээс санал авсан ба холбогдох тооцооллыг хийж байна. | | |
| 1.2.3 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд улирал бүр дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулна. | -Дата анализ хийгдсэн тоо<br>-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Дата мэдээллээр хангах, боловсруулах | Сар бүр тогтмол ерөнхий дата мэдээллээр мэргэжилтэн бүрийг хангах | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11, 2023 оны 10, 2024 оны 05, 06 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцад дата анализ хийж ажиллахад шаардлагатай дата, мэдээллийг сар бүр 12 удаа таблю системээс гарган холбогдох мэргэжилтэнд хүргэн мэдээллээр ханган ажилласан.<br>2024 оны байдлаар өмнөх тогтоолуудын хэрэгжилт, үр дүнд үнэлгээ хийх чиглэлээр ажилласан бөгөөд үнэлгээний мөрөөр тогтоолуудад холбогдох өөрчлөлтийг тусгаж шинэчлэн батлуулахад холбогдох бодлогын саналыг боловсруулсан. Мөн амбулаторийн тусламж, үйлчилгээний өмнөх саруудын гүйцэтгэл, нэг даатгуулагчид ногдох өртгийг эрүүл мэндийн байгууллага тус бүрээр 2024 оны сар бүрийг мөн үе, өмнөх сартай харьцуулсан дата мэдээллийг боловсруулан холбогдох тогтоолын өөрчлөлтөөр бодлогын хувилбар боловсруулан ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |
| 1.2.4 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжүүлэх хэрэгжилтийг ханган ажиллана. | - Санхүүжүүлсэн мөнгөн дүн<br>- Хамрагдсан даатгуулагчийн тоо | Дата мэдээллээр хангах | Ерөнхий дата мэдээллээр хангах | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхэд шаардлагатай сар бүрийн тоо хэмжээ, мөнгөн дүн, холбогдох дата мэдээллийг бэлтгэж, сар бүр 12 удаа холбогдох мэргэжилтэнд хүргэж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |
| **Зорилт 1.3. Цахим шилжилтэд бүрэн шилжинэ.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.1 | Арга хэмжээ 3.1. Арга хэмжээ 3.2. ЭМДҮЗ-ийн "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоолын хүрээнд бодлогын даалгавар боловсруулан эрүүл мэндийн даатгалын цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийхэд хамтран оролцоно. | Боловсруулсан бодлогын даалгаврын тоо | Бодлогын даалгавар боловсруулсан байна. | Бодлогын даалгавар боловсруулах, Эрүүл мэндийн дааатгалын цахим системд холбогдох өөрчлөлтийг хамтран оруулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар тогтоолын дагуу шаардлагатай нэмэлт өөрчлөлтийн даалгаврыг боловсруулж, дотоод албан бичгээр 4 удаа МТХ-т хүргүүлэн, холбогдох өөрчлөлтийг хамтран оруулсан байна. | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| 1.3.2 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэн хүн амд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тоон үзүүлэлтээр дашборд үгсрах, шийдвэр гаргагч болон бусад талууд, олон нийтэд мэдээлнэ. | Дашбоард хийгдсэн байна. | Дашбоард хийгдээгүй | Дашбоард хийгдэхэд шаардлагатай тоо мэдээллийг нэгтгэх | Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын 2022 оноос хойшхи сар бүрийн нэхэмжлэлийн тоо, хэмжээ, мөнгөн дүн харуулсан дашбоардыг угсарсан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудад олгохоор тооцсон мөнгөн дүн, анхан шатны нэг иргэний 20 хувийн гүйцэтгэлийн үнэлгээ, санхүүжилт, хамралт, орлого, зарлагыг харуулсан дашбоардыг үүсгэсэн. Цаашид сар бүр дашбоард үүсгэхэд шаардлагатай тоо мэдээллийг холбогдох газар хэлтсүүдээс авч байх загвар маягт гарган Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. | 2024.01.01 2024.12.31 | 90% |
| 1.3.3 | ЭМДҮЗ-ийн "Багц төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" дугаар тогтоолын | Нэмэлт хөгжүүлэлтийн даалгаврын тоо | 2023 онд 1 бодлогын даалгавар боловсруулсан байна | Бодлогын даалгавар боловсруулах, Эрүүл мэндийн дааатгалын цахим системд | Эрүүл мэндийн даатгалын цахим системд шинэчилсэн тогтоолын үндсэн бодлогын даалгаврыг боловсруулж хүргүүлэн, цахим системд холбогдох өөрчлөлтийг Мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэнтэй хамтран | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дагуу эрүүл мэндийн даатгалын цахим хяналтын шүүлтүүр ажиллаж буй эсэхэд хяналт хийж, сайжруулалтын арга хэмжээ авч ажиллана. | | | холбогдох өөрчлөлтийг хамтран оруулсан байна. | оруулсан байна. Цахим системд нэмэлт, өөрчлөлт оруулах дотоод бичгийг 5 удаа хүргүүлэн холбогдох өөрчлөлтийг оруулсан байна. | | |
| **Зорилт 1.4. Салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| 1.4.1 | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох хууль тогтоомжид санал боловсруулж, Эрүүл мэндийн яамтай хамтран ажиллана. | Хүргүүлсэн санал | Нийт 4 хуулийн нэмэлт өөрчлөлтөд 151 санал хүргүүлж, байгууллагын онцлог, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн. | Холбогдох хуулийн төслүүдэд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу санал боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна. | "Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг судлан холбогдох саналыг албан бичгээр хүргүүлсэн. | 2024.01.01<br>2024.03.30 | 100% |
| **Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна.** | | | | | | | |
| **Зорилт 3.2.Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна.** | | | | | | | |
| 3.2.1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цахим хяналтын шүүлтүүр ажиллаж буй эсэхэд хяналт хийж, сайжруулалтын арга хэмжээ авч ажиллана. | Цахим хасагдлын тохиолдлын тоо, мөнгөн дүн | 2023 онд нийт 198 шалгуураар 125 сая тохиолдол, 120,5 тэрбум төгрөгийн хасагдал хийгдсэн. | Эрүүл мэндийн дааатгалын цахим системд тоттмол хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын цахим системд үндсэн тогтоолын бодлогын даалгаврын хяналтыг тогтмол хийн, хяналтын үр дүнд нийт 3 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах дотоод албан бичгийг Мэдээллийн технологийн хэлтэст хүргүүлэн ажилласан байна. ЭМДҮЗ-ийн 2023 оны 08, 2024 оны 06 дугаар тогтоолын хүрээнд 10,123.597 тохиолдлын 1,351,088,110,621 төгрөг нэхэмжилсэнээс 287,207 тохиолдлын 18,698,360,774 төгрөг, ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар тогтоолын хүрээнд 4,473,377,000 төгрөг, ЭМДҮЗ-ийн 2023 | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны 06, 2024 оны 05 дугаар тогтоолын 638,354,370 төгрөг, ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хүрээнд 6,798,429,222 төгрөгийг цахим системээр тооцоолж хасалт хийсэн байна. | | |
| 3.2.2 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн нийт мэдээлэлд үндэслэн түүврийг сонгож, холбогдох нэгжид хүргүүлэх | | Зорилтот түүвэр 2023 онд нийт нэхэмжлэлийн ... хувь байна. | Сар бүр түүврийн мэдээллийг хүргүүлсэн байна. | ЭМДҮЗ-ийн "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 06 дугаар тогтоол шинэчлэгдэн батлагдсантай холбоотой ТҮЧТХГ-т дотоод албан бичгээр түүвэр хийх оношийн хамааралтай бүлгийн жагсаалтыг хүргүүлэн ажилласан. | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| **Зорилго 4. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | |
| **Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө.** | | | | | | | |
| 4.1.1 | Төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, сургалт хийнэ. | Сургалтын тоо | Нийт 6 удаагийн нэгдсэн сургалтаар давхардсан тоогоор 330 албан хаагчид сургалт хийсэн. | | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05, 06 дугаар тогтоолуудын танилцуулга, сургалтыг төв орон нутгийн эрүүл мэндийн даатгалын нэгжийн албан хаагчдад 3 удаа, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд шинэчилсэн тогтоолын сургалт, хэлэлцүүлэг 4 удаа хийсэн. | 2024.01.01 2024.11.30 | 100% |
| 4.1.2 | Гэрээтэй ЭМБ-дад сургалт зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах үйл ажиллагааг зохион байгуулна. | Сургалтын тоо | Нийт 16 удаагийн нэгдсэн сургалтаар нийт анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад сургалт хийсэн байна. | | 2023 оны 06 болон 08 дугаар тогтоолыг шинэчлэхээр санал авах, хэлэлцүүлэг сургалтыг ЭМДЕГ-ын даргын баталсан хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор зоомээр 7 удаа 250, танхимаар УНТЭ, Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газруудад нийт 127 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан зохион байгуулж ажилласан. Мөн лабораторийн үндэсний чуулгант танилцуулга бэлтгэн оролцсон ба төвлөрлийг сааруулах үндэсний багийн Хэнтий, Өмнөговь, Орхон аймгуудад хийсэн уулзалтын таницуулга мэдээллийг боловсруулж ажилласан. | 2024.01.01 2024.11.30 | 100% |
| 4.1.3 | Иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн | Арга хэмжээний тоо | Нийт удаагийн мэдээллийг иргэн | | Тогтоолын өөрчлөлтийн талаар TV-8, Eagle телевизд 3 удаа, ЭМДЕГ-ын цахим хуудсанд 5 удаагийн мэдээллийг иргэн даатгуулагчид хүргэн ажилласан. Мөн битүүмж, | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | даатгалын үйл ажиллагааг сурталчлан таниулах арга хэмжээг бусад газар, хэлтэстэй хамтран хэрэгжүүлнэ. | | даатгуулагчдад хүргэсэн байна. | амбулаторийн хяналтын үзлэгт, нэг иргэний санхүүжилтын мэдээллийг 6 удаа, иргэдэд тогтоолын өөрчлөлтийн талаар мэдээллийг тухай бүр өгч ажилласан. | | |
| 4.1.4 | Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 лавлах утсаар дамжиж хандсан, 7010-1125 утсанд ирсэн дуудлаганд даатгуулагч-иргэдийн эрүүл мэндийн даатгалын талаарх төрийн үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө, мэдээлэл хүргэж, санал гомдлыг шийдвэрлэнэ. | Шийдвэрлэлтийн тоо | 2023 онд 10 утсаар болон биеэр ирсэн асуулт, санал хариу, зөвлөгөө өгч ажилласан. | Иргэн даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагаас утсаар дамжин ирсэн 12 асуулт, санал гомдол, асуултын хариулт, мэдээлэл, зөвлөгөө өгч, бүрэн барагдуулж ажилласан. Түгээмэл ярьсан тохиолдол нь нэг иргэний 20 хувийн шалгуур үзүүлэлтийн бодолт болон ЭМДҮЗ-ийн 08 дугаар тогтоолын өөрчлөлт, амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний талаар тодруулга мэдээлэл байсан болно. | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |
| 4.1.5 | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврын дагуу хэрэгжүүлнэ. | Албан бичиг шийдвэрлэлтийн хувь | 2023 оны албан бичиг шийдвэрлэлт 95% хувь | Нийт тайлант хугацаанд 29 албан бичиг ирснээс хариутай 21 бичигт хугацаа хэтрүүлэлгүй албан хариуг өгч, хариугүй 8 албан бичгийг тухайн байгууллагатай холбогдон асуудлыг шийдвэрлэн ажилласан. | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |
| 4.1.6 | Засгийн Газрын "Иргэд, олон нийттэй харилцах-1111" төвөөс ирсэн санал, гомдлыг шуурхай шийдвэрлэнэ. | Тухай бүр | 2023 онд 10 гомдлыг шийдвэрлэн ажилласан байна. | "Иргэд, олон нийттэй харилцах-1111" төвөөс ирсэн 14 санал, гомдлыг хуулийн хугацаанд барагдуулж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.7 | Газрын дарга болон нэгжийн даргын өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хангана | Тухай бүр | 2023 онд газрын дарга болон нэгжийн даргын өгсөн хугацаатай 7 үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан байна. | Газар, хэлтсийн удирдлагаас өгсөн дараах үүрэг даалгаврыг гүйцэтгэсэн.<br>• Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын шалгуурыг урьдчилсан байдлаар үнэлж танилцуулсан.<br>• Нэг иргэний санхүүжилтийг нийт 505 анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 30,0 тэрбум төгрөг олгохоос холбогдох тооцоолол, бодолтыг хийн, тулган баталгаажуулж 25,2 тэрбум төгрөгийг олгохоор тооцон СТХ-т сар бүр шилжүүлсэн. Мөн Эрүүл мэндийн яам, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хагас жилээр нийт үнэлгээг хүргүүлэн ажилласан.<br>• "Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийх ажлын удирдамж"-ийн дагуу эрүүл мэндийн салбарын нөхцөл байдлын шинжилгээ хийхэд 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд ажилласан.<br>• ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/46, А/84, А/117 дугаар тушаалын дагуу тендерийн үнэлгээний хорооны гишүүн, нарийн бичгийн дарга, үнэлгээний хорооны даргаар ажиллаж 14 удаагийн хуралд оролцож, тендерийн баримт бичгийг боловсруулан, цахим системд оруулан, байгууллагыг сонгон шалгаруулж, захиалагчид зөвлөмж өгч ажилласан.<br>• Ерөнхий сайдын дүүргүүдийн иргэдтэй хийх уулзалттай холбоотой 2023 оны нийслэлийн гэрээ бүхий эмийн сангийн тоо мэдээллийн нэгтгэлийг гаргасан. | 2024.01.01<br>2024.11.30 | 100% |
| **Зорилт 4.2. Дотоод зохион байгуулалтын ажилд оролцох, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 4.2.1 | Газар, хэлтсийн хэмжээнд болон чиг үүргийн хүрээнд явагдах семинар, зөвлөгөөн, өдөрлөг, | Гүйцэтгэсэн ажлын тоо | | Зохион байгуулсан арга хэмжээнд бүрэн оролцож ажиллаж байна. Мөн цахим эрүүл мэнд сургалт, ТАЗ-ийн 7:4:10 сургалтад тогтмол хамрагдан ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | сургалтын зохион байгуулалт, олон нийтийн ажилд идэвхтэй оролцоно. | | | | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрсэн түвшин | | Эхлэх, дуусах хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Эрүүл мэндийн даатгалын системд холбогдох төсөл хөтөлбөр, уулзалт, хурал, мэдээлэлд оролцох | Сургалт, хурлын тоо | Сургалт, вебинарт оролцсон байна. | Анхан шатны гүйцэтгэлийн үнэлгээ сайжруулахад улс орон бүрийн туршлагыг судлах "JLN Learning collaborative on PHC Permormance Management" хөтөлбөрт хамрагдаж 5 удаагийн цахим уулзалтад оролцсон ба Бүгд Найрамдах Кени улсад 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс 10 дугаар сарын 28-ны өдрүүдэд "Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн менежмент" сэдэвт чуулганд оролцсон.<br>Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хийгдэж байгаа олон улсын зөвлөх Сара Бэйлис-тай хамтарсан сургалтад 6 удаа оролцсон.<br>Солонгос улсын Сөүл хотноо 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс 09 дүгээр сарын 27-ны өдрийдэд "Эрүүл мэндийн санхүүжилт, нийгмийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, урт хугацааны даатгалын менежмент" сэдэвт зөвлөлдөх уулзалтад оролцсон. | | 2024.01.01<br>2024.11.30 | 100% |

**ТАЙЛАН БИЧСЭН:**

Тусламж, үйлчилгээний багц хариуцсан ахлах мэргэжилтэн .............................. (Д.Булгантамир) .........................